



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

# **БАЙГУУЛЛАГЫН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**/ЭХНИЙ ХАГАС ЖИЛ/**

**УЛААНБААТАР ХОТ  
2022 он**

## АГУУЛГА

### ТАНИЛЦУУЛГА

- ✓ Танилцуулга
- ✓ Алсын хараа
- ✓ Эрхэм зорилго
- ✓ Үндсэн чиг үүрэг..... 2-3 хуудас

### БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- ✓ Бүтэц, зохион байгуулалт ..... 4 хуудас

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

- ✓ Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт
- ✓ Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт
- ✓ Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт
- ✓ Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн байгаль орчин, аялал жуулчлалын салбарт 2022 онд хамтран ажиллах гэрээнд туссан арга хэмжээний хэрэгжилт
- ✓ Нийслэлийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт ..... 5-7 хуудас

### ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

- ✓ Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт
- ✓ Захирамжлалын баримт бичгийн биелэлт
- ✓ “Хотын иргэний жил”-ийн төлөвлөгөөний биелэлт..... 7-8 хуудас

### ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

- ✓ Байгууллагын дүрмээр хүлээсэн үүргийн хэрэгжилт
- ✓ Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийн хэрэгжилт
- ✓ Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах чиглэлээр
- ✓ Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ
- ✓ Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны чиглэлээр
- ✓ “Нийслэлийн хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан”-д оруулсан тайлан мэдээ..... 8-29 хуудас

### ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

- ✓ Үйл ажиллагааны ил тод байдал
- ✓ Хүний нөөцийн ил тод байдал ..... 30 хуудас

### ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД МЭДЭЭЛЭЛ

- ✓ Чиг үүргийн хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны бусад байгууллагатай ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр
- ✓ Үндсэн үйл ажиллагаа явуулахад гарч байгаа хүндрэл, бэрхшээл болон цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаарх санал, хүсэлт..... 30-33 хуудас

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

**“ТАНИЛЦУУЛГА”**

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 68 дугаар тогтоолоор Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Аялал жуулчлалын газар ажиллуулахаар тогтоож, Нийслэлийн Засаг даргын 2009 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 14 дүгээр захирамжаар 12 орон тоотой үүнээс дарга -1 байхаар баталж, Газрын даргын 2009 оны 01 дүгээр тушаалаар ахлах мэргэжилтэн-2, мэргэжилтэн-9 албан хаагчтай анх үйл ажиллагаагаа эхэлсэн.

Нийслэлийн Засаг даргын 2013 оны “Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрэм, бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай” А/323 дугаар захирамжаар газрын бүтэц, орон тоог нэмэгдүүлэн шинэчлэн 18 орон тоотой байхаар баталж, үүнээс дарга 1, ахлах мэргэжилтэн-2, мэргэжилтэн-12 /ТЗ/, мэдээллийн төвийн менежер-1, мэдээллийн технологи хариуцсан инженер-1, архив, бичиг хэргийн эрхлэгч-1 /ТҮ/ албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа өргөжүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын 2016 оны “Дүрэм батлах тухай” А/831 дүгээр захирамжаар тус газрын дүрэм, 2019 оны А/241 дүгээр захирамжаар бүтэц, орон тооны хязгаарыг баталж, газрын дарга-1, орлогч дарга-1, Захиргааны хэлтэс-6, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс-5, Мэдээлэл, сурталчилгааны хэлтэстэй-5 буюу үндсэн ажилтан 18, хөдөлмөрийн гэрээгээр мэдээлэл, сурталчилгааны төвийн ажилтан-3, нийт 21 албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулав.

Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/1059 дүгээр захирамжаар тус газрын бүтэц, орон тооны хязгаарыг 18 байхаар баталж, үүнээс дарга-1, Захиргаа, санхүүгийн хэлтэс, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс гэсэн 2 зохион байгуулалтын нэгжтэй байхаар баталсан.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар “Газрын дүрэм”-ийг шинэчлэн батлуулж үйл ажиллагаандаа мөрдөж, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөө, “Хотын иргэний жил”-ийн арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийслэл хотод аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага аж ахуйн нэгж, иргэдийг мэргэжлийн удирдлага, дэмжлэгээр хангах, нийслэл хотыг гадаад, дотоодод сурталчлах, төрөөс аялал жуулчлалын чиглэлээр баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомжийг мөрдүүлэхэд гол үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.

✓ **АЛСЫН ХАРАА:**

Албан бизнесийн аялал жуулчлал болон нүүдэлчдийн түүх өв уламжлалыг хадгалсан соёлын үйлдвэрлэл, үйлчилгээ бүхий Монгол Улсын аялал жуулчлалын гол зангилаа байна.


✓ **ЭРХЭМ ЗОРИЛГО:**

Нийслэл Улаанбаатар хотыг үндэсний онцлог бүхий аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ өндөр хөгжсөн, олон улсад өрсөлдөх чадвартай хот болгон хөгжүүлэхэд оршино.

✓ **ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ:**

- ❖ аялал жуулчлалын болон жуулчны үйлчилгээний байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хамтарч ажиллах;
- ❖ аялал жуулчлалын байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;
- ❖ нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, Улаанбаатар хотыг гадаад улсад сурталчлах маркетингийн төлөвлөгөө боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;
- ❖ нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр их, дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, эрдэмтэн, судлаачидтай хамтран судалгаа хийж, хэлэлцүүлэг зохион байгуулах;
- ❖ нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр гадаад, дотоодын байгууллагуудтай хамтарч ажиллах;
- ❖ аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөөг нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;
- ❖ аялал жуулчлалын салбарын хөгжлийн чиг хандлага, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах;
- ❖ жуулчдыг татах болон аялал жуулчлалын салбарт соёлын нөлөөллийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;
- ❖ гадаад оронд зохион байгуулагдах аялал жуулчлалын хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн, арга хэмжээнд аялал жуулчлалын болон жуулчны үйлчилгээний байгууллагуудыг хамруулах;
- ❖ нийслэлийн аялал жуулчлалын нөөцөд түшиглэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, шинээр бий болгох ажлыг зохион байгуулах;
- ❖ гадаад, дотоодын жуулчдыг хэрэгцээт мэдээллээр хангах, мэдээллийн товхимлуудыг тогтмол шинэчлэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх;
- ❖ нийслэлийн хэмжээнд аялал жуулчлалын салбарын мэдээллийн санг хөтлөх;
- ❖ “жуулчны мэдээллийн төв”-үүдийн үйл ажиллагааг өргөжүүлэх;
- ❖ жуулчдын санал, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх;
- ❖ гадаад, дотоодын жуулчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй орчинд зорчих, аялах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах.

## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2022 ОНЫ  
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022 оны 06 дугаар сарын 15

Улаанбаатар хот

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

**а./ Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр:**

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2 зорилтын 3 арга хэмжээний биелэлт 2022 оны эхний хагас жилийн байдлаар 63.3 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгтээр үзүүлбэл:

“Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийн дүн		
Нийт арга хэмжээний тоо		3
1. Бүрэн хэрэгжсэн	100 хувь	1
2. Үр дүн гарсан	90 хувь	-
3. Тодорхой хэмжээнд үр дүн гарсан	70 хувь	2
4. Ажил эхэлсэн	50 хувь	1-
5. Боловсруулалтын шатанд	30 хувь	-
6. Бэлтгэл ажлыг хангаж байгаа /ажил зохион байгуулаагүй	0 хувь	-
Хэрэгжилтийн хувь		63.3%

**б./ Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл:**

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/09 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 1 зорилтын 3 арга хэмжээний биелэлт 2022 оны эхний хагас жилийн байдлаар 56.6 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгтээр үзүүлбэл:

“Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийн дүн		
Нийт ажлын тоо		3
1. Бүрэн хэрэгжсэн	100 хувь	-
2. Үр дүн гарсан	90 хувь	-
3. Тодорхой хэмжээнд үр дүн гарсан	70 хувь	1
4. Ажил эхэлсэн	50 хувь	2
5. Боловсруулалтын шатанд	30 хувь	-
6. Бэлтгэл ажлыг хангаж байгаа /ажил зохион байгуулаагүй	0 хувь	-
Хэрэгжилтийн хувь		56.6%

**в./ Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр:**

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/10 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024

оны үйл ажиллагааны хөтөлбөр”, нийслэлийн Засаг даргын 2021 оны А/115 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 5 зорилтын 11 арга хэмжээний биелэлт 2022 оны эхний хагас жилийн байдлаар 57.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгтээр үзүүлбэл:

“Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийн дүн		
Нийт ажлын тоо		11
1. Бүрэн хэрэгжсэн	100 хувь	-
2. Үр дүн гарсан	90 хувь	-
3. Тодорхой хэмжээнд үр дүн гарсан	70 хувь	4
4. Ажил эхэлсэн	50 хувь	7
5. Боловсруулалтын шатанд	30 хувь	-
6. Бэлтгэл ажлыг хангаж байгаа /ажил зохион байгуулаагүй	0 хувь	-
Хэрэгжилтийн хувь		57.0%

**г./ Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай байгуулсан хамтран ажиллах гэрээ:**

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн байгаль орчин, аялал жуулчлалын салбарт 2022 онд хамтран ажиллах гэрээнд туссан арга хэмжээний 1 зорилтын 15 арга хэмжээний биелэлт 2022 оны эхний хагас жилийн байдлаар 67.0 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгтээр үзүүлбэл:

“Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай байгуулсан хамтран ажиллах гэрээний арга хэмжээний хэрэгжилтийн дүн		
Нийт ажлын тоо		15
1. Бүрэн хэрэгжсэн	100 хувь	3
2. Үр дүн гарсан	90 хувь	-
3. Тодорхой хэмжээнд үр дүн гарсан	70 хувь	1
4. Ажил эхэлсэн	50 хувь	6
5. Боловсруулалтын шатанд	30 хувь	-
6. Бэлтгэл ажлыг хангаж байгаа /ажил зохион байгуулаагүй	0 хувь	-
7. Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	-	5
Хэрэгжилтийн хувь		67.0%

**д./ Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөө:**

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 11/31 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний 1 зорилтын 19 арга хэмжээний биелэлт 2022 оны эхний хагас жилийн байдлаар 62.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгтээр үзүүлбэл:

“Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн дүн		
Нийт ажлын тоо		19
1. Бүрэн хэрэгжсэн	100 хувь	3
2. Үр дүн гарсан	90 хувь	-



3. Тодорхой хэмжээнд үр дүн гарсан	70 хувь	4
4. Ажил эхэлсэн	50 хувь	12
5. Боловсруулалтын шатанд	30 хувь	-
6. Бэлтгэл ажлыг хангаж байгаа /ажил зохион байгуулаагүй	0 хувь	-
7. Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	-	-
Хэрэгжилтийн хувь		62.0%

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, 2021 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 374 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын хүрээнд бодлогын баримт бичгийн 2022 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, шалгуур үзүүлэлтийн тайлангийн хамт Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт- шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн.

### ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

#### а./ Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн хүрээнд Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр өгсөн 1 заалт үүрэг даалгаврын биелэлт 90.0%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжиж, тайлан мэдээг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлж тайлагнасан.

Төрлөөр нь авч үзвэл:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн төрөл	Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо	Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо	Бүрэн хэрэгжсэн /90-100/	Хэрэгжих шатандаа /50-89/	Хэрэгжилт хангалтгүй /10-49/	Хэрэгжээгүй /0-9/	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	Биелэлтийн дундаж
Монгол Улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	1	1	1					90.0%
<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>1</b>					<b>90.0%</b>

#### ✓ Захирамжлалын баримт бичгийн хэрэгжилт:

Байгууллагын хэмжээнд тайлант хугацаанд 10 захирамжлалын баримт бичгийн нийт 20 заалт буюу Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 1 тогтоол шийдвэрийн 1 заалт үүрэг даалгаврын хэрэгжилт 70.0%, Нийслэлийн Засаг даргын 2 захирамжийн 6 заалт үүрэг даалгаврын хэрэгжилт 93.3%, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн Хурлын 7 тэмдэглэлийн 13 заалт үүрэг даалгаврын хэрэгжилт 95.3%-ийн хэрэгжилттэй үнэлэгдсэн.

-Захирамжлалын баримт бичгийн 20 заалт үүрэг, даалгавраас бүрэн хэрэгжсэн 16, хэрэгжих шатандаа 4 буюу 86.2% гүйцэтгэлтэй үнэлэгдэж, тайлан мэдээг хугацаанд нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн бөгөөд [www.monitoring.ulaanbaatar.mn](http://www.monitoring.ulaanbaatar.mn) цахим програмаар тайлагнасан.

Төрлөөр нь авч үзвэл:



Захирамжлалын баримт бичгийн төрөл	Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо	Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо	Бүрэн хэрэгжсэн /90-100/	Хэрэгжих шатандаа /50-89/	Хэрэгжилт хангалтгүй /10-49/	Хэрэгжээгүй /0-9/	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	Биелэлтийн дундаж
Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол	1	1		1				70.0%
Нийслэлийн Засаг даргын захирамж	2	6	5	1				93.3%
Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл	7	13	11	2				95.3%
<b>НИЙТ</b>	<b>10</b>	<b>20</b>	<b>16</b>	<b>4</b>				<b>86.2%</b>

**б./ “Хотын иргэний жил”-ийн төлөвлөгөөний хэрэгжилт:**

Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/01 дүгээр захирамжаар 2022 оныг “Хотын иргэний жил” болгон зарласантай холбогдуулан нийслэлийн нэгдсэн төлөвлөгөөтэй уялдуулан тус газраас хэрэгжүүлэх дүрэм, стандартыг сурталчлах, хотын соёлыг төлөвшүүлэх, хөдөлмөр эрхлэлт, орлого нэмэгдүүлэх, амьдрах орчныг сайжруулах чиглэлээр 4 зорилтын 15 арга хэмжээний төлөвлөгөөг баталж, “Хотын иргэний жил”-ийн төлөвлөгөөний биелэлт 2022 оны хагас жилийн байдлаар 73.3%-ийн гүйцэтгэлтэй гарч, хэрэгжилтийг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлэв.


**ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН**

**а./ Газрын дүрмээр хүлээсэн үүргийн хэрэгжилт:**

- ✓ аялал жуулчлалын болон жуулчны үйлчилгээний байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хамтарч ажиллах;

Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлж, авилга, хүнд суртлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/987 дугаар захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд үйлчилгээний байгууллагуудыг системд хамруулах, бүртгүүлэх зорилгоор байгууллагын [www.ub.gov.tourism.mn](http://www.ub.gov.tourism.mn) цахим хуудас, газрын facebook хуудсанд мөрдөгдөж буй стандарт, тавигдах шаардлагыг ханган татварын албанд бүртгүүлснээр нийслэлийн нутаг дэвсгэрт байр сууцны үйл ажиллагаа эрхлэх талаар холбогдох мэдээллийг аж ахуйн нэгж, байгууллагуудад өгч, арга зүйн удирдлагаар ханган ажилласан.

“Онлайн бизнес” төвийн Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн нэгдсэн системд тайлант хугацаанд 155 аж ахуйн нэгж, байгууллага зочид буудал, дэн буудал, амралтын газрын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхээр хүсэлт гаргасан бөгөөд үүнээс шийдвэрлэсэн-30, шилжүүлсэн-112, судалж байгаа -0, илгээсэн-0, татгалзсан-2, буцаасан 11 гэсэн явцтай байна.



- ✓ аялал жуулчлалын байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;

Монгол Улсын Засгийн газрын ээлжит бус хуралдаанаар гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг цуцалж, шар түвшинд шилжүүлсэнтэй холбогдуулан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас санаачлан 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулагдсан “Шинэ сэргэлтийн бодлого-Аялал жуулчлал” хэлэлцүүлэг, “Монголын эдийн засгийн чуулган 2022- Шинэ сэргэлт”, “Аж үйлдвэржилтийн сэргэлт” урьдчилсан хэлэлцүүлгийн хүрээнд 03 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулагдсан “Шинэ сэргэлтийн бодлого-Аялал жуулчлал” хэлэлцүүлэгт давхардсан тоогоор салбарын нийт 250 гаруй аж ахуйн нэгж, байгууллагуудын төлөөллийг оролцуулсан.



#### ❖ “HOSPITALITY-2022” нэгдсэн арга хэмжээ

Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Аялал жуулчлалын арга хэмжээ зохион байгуулах тухай” А/530 дугаар захирамжийн дагуу Нийслэлийн Аялал жуулчлалын газраас Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монголын Зочид буудлуудын холбоотой хамтран “HOSPITALITY-2022” нэгдсэн арга хэмжээг “Зочид буудал, зоогийн газрын хангамжийн үзэсгэлэн, зочлох үйлчилгээний салбарын мэргэжлийн аварга шалгаруулах тэмцээн, “Аялал жуулчлал ба ажил эрхлэлт”, “Зочлох үйлчилгээний салбарын цахим шилжилт, шийдэл” хэлэлцүүлэг” гэсэн 4 чиглэлээр 2022 оны 05 дугаар сарын 13,14-ний өдрүүдэд Улаанбаатар зочид буудлын үзэсгэлэнгийн танхимд зохион байгуулав.

Арга хэмжээний нээлтэд Нийслэлийн Засаг даргын Нийгмийн хөгжил, боловсрол, эрүүл мэндийн асуудал хариуцсан орлогч З.Төмөртөмөө, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга Д.Батсүх, Монголын Зочид буудлуудын холбооны ерөнхийлөгч С.Мөнхбат нар оролцон бөгөөд арга хэмжээг 5000 гаруй иргэн үзэж, сонирхож, 10 гаруй телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахимаар 42.000 гаруй хүнд сурталчилсан.

ЕРӨНХИЙ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

“ЗОЧИД БУУДАЛ, ЗООГИЙН ГАЗРЫН ХАНГАМЖИЙН ҮЗЭСГЭЛЭН- 2022”, “ЗОЧЛОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ЦАХИМ ЦАЛГАЛТ” ХЭЛЭГЛҮҮЛЭГ, “ЗОЧЛОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭРГЭЖЛИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН”, “АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ БА АЖИЛ ЭРХЛЭЛТ” ХӨВДӨЛМӨРНИЙ РАЯМА ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГАХЭМЖЭЭНИЙНГЭДСЭН ХӨТӨЛБӨР



**HOSPITALITY - 2022**  
HOTEL AND RESTAURANT CATERING

Хаяв: Улаанбаатар зочид буудал "EVENT HALL" танинд  
Хэвээ: 2022 оны 05 дугаар сарын 13, 14-ний өдөрүүдэд

Цаг	Арга хэлцэл
<b>2022 оны 05 дугаар сарын 13-ны өдөр</b>	
09:00-10:00	Тасвирын өдөр амжилтын эхлэл
09:00-12:30	"Зочлох үйлчилгээний салбарын цахим цалгалт" хэлэлцүүлэг
10:00-12:30	"Зочин агуулам ажил" мэргэжлийн аварга шалгаруулах тэмцээн
12:30-13:00	Ирээдүйн арга хэлцэл
13:00-16:00	"Бар тендер" мэргэжлийн аварга шалгаруулах тэмцээн
13:00-16:00	"Өрөө үйлчилгээ" мэргэжлийн аварга шалгаруулах тэмцээн
10:00-16:00	"Ажил амжилал ба мэдлэг эрэлт" ирдэгчдийн өрсөлт
<b>2022 оны 05 дугаар сарын 14-ний өдөр</b>	
09:00-10:00	Тасвирын өдөр амжилтын эхлэл
10:00-12:00	"Ажил амжилал ба мэдлэг эрэлт" ирдэгчдийн өрсөлт
09:00-11:00	"Зочин" мэргэжлийн аварга шалгаруулах тэмцээн
11:00-13:00	Шавар, тосгоны баг" аян хэлт тэмцээн
15:00-17:00	Ирээдүйн төлөлт ивэн тэтгэгч байгууллагын танилцуулга
17:00-18:00	Цахим сурталчилгаа үйл ажиллагаа, эргэлтэн таларх
18:00	Хуульч үйл амжилтын



**“Зочид буудал, зоогийн газрын хангамжийн үзэсгэлэн”**


Зочлох үйлчилгээний салбарт инновацийг нэвтрүүлэх, зах зээлээ өргөжүүлэх, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх, түншлэл бий болгох, бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг дэмжих зорилгоор зохион байгуулсан “Зочид буудал, зоогийн газрын хангамжийн үзэсгэлэн”-д орон нутгийн Аялал жуулчлалын газрууд, салбарын мэргэжлийн холбоод, зочлох үйлчилгээний чиглэлээр боловсон хүчин бэлтгэдэг их, дээд сургууль, нийслэлээс “Холидэй инн”, “Рамада”, “Рэдрок”, “Ибис”, “Тайж”, “Миллениум”, “Гранд хилл”, “Аврора”, орон нутгаас Өвөрхангай аймгийн “Богд”, Баян-Өлгий аймгийн “Памакула”, Хэнтий аймгийн “Хан бүргэдэй” зочид буудлууд, зочид буудлын хэрэгсэл, тоног төхөөрөмж нийлүүлдэг “Гүрмэ”, “The queens home”, “Eco lab” “Mongolia, Тулга” төхөөрөмж ХХК, хүнсний бүтээгдэхүүн нийлүүлдэг “We international” ХХК, “Алтан тариа”, “Бат байгаль”, “АПУ”, “Хан бүргэдэй” зэрэг 45 байгууллага бараа бүтээгдэхүүн, үйл ажиллагаагаа сурталчилж оролцсон.



**“Зочлох үйлчилгээний салбарын мэргэжлийн аварга шалгаруулах тэмцээн”**

Салбарын хүний нөөцийг чадваржуулах, туршлага солилцох, ажил мэргэжлийг сурталчлах зорилгоор “Зочлох үйлчилгээний салбарын мэргэжлийн аварга шалгаруулах тэмцээн”-ийг 2 үе шаттай зохион байгуулж, тэмцээнд “Бишрэлт”, “Сан”, “Холидэй инн”, “Ибис”, “Ханбүргэд” зочид буудал /Хэнтий аймаг/, “Жаргалант” амралт, сувилал зэрэг байгууллагын 41 ажилтан “Зочин хүлээн авагч”, “Өрөө үйлчилгээ”, “Зөөгч”, “Бар-тендер” гэсэн ажил мэргэжлээр шилдгүүдээ тодруулж, ажил мэргэжлээ тэргүүлсэн оролцогчдод 1 сая төгрөгийн шагнал, урамшуулал олгосон.





### “Зочлох үйлчилгээний салбарын цахим шилжилт, шийдэл” хэлэлцүүлэг

Зочлох үйлчилгээний салбарт дэвшилтэд технологи нэвтрүүлэх, үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх, цахим хэлбэрт шилжүүлэх зорилгоор зохион байгуулагдсан “Зочлох үйлчилгээний салбарын цахим шилжилт, шийдэл” хэлэлцүүлэгт зочид буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 60 гаруй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөл оролцож санал бодлоо хуваалцсан.



### “Аялал жуулчлал ба ажил эрхлэлт”

Аялал жуулчлалын салбарт ажиллах сонирхолтой оюутан залуус, иргэдийг эзэмшсэн мэргэжлийнхээ дагуу түр болон байнгын ажлын байртай болгох, аялал жуулчлалын байгууллагуудад шаардлагатай ажилтнаа олоход нь дэмжлэг үзүүлэх, ажил олгогч, ажил хайгч иргэдийг холбох зорилгоор “Аялал жуулчлал ба ажил эрхлэлт” хөдөлмөрийн яармагт жуулчны бааз, тур оператор компани, зочид буудал, зоогийн газар зэрэг аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудаас ирүүлсэн 252 нээлттэй ажлын байрны мэдээллийг 2 үзэсгэлэн, арга хэмжээний үеэр 800 гаруй иргэнд сурталчлан, ажлын байранд шууд зуучлах, нээлттэй ажлын байр зарласан

жуулчны бааз, тур оператор, зоогийн газар, зочид буудлын ажил олгогчид ажилд бүртгэх ажлыг хамтран зохион байгуулсан.



Нийслэлийн Аялал жуулчлалын газар

Visit Ulaanbaatar  
CITY OF HAPPINESS




- ЖУУЛНЫ БААЗ
- АМРАЛТЫН ГАЗАР
- ЗОЧИД БУУДАЛ
- ЗООГИЙН ГАЗАР
- ТУР ОПЕРАТОР
- РАШААН СУВИЛАЛ
- МУЗЕЙ

70128687



✓ нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, Улаанбаатар хотыг гадаад улсад сурталчлах маркетингийн төлөвлөгөө боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;


Улаанбаатар хотыг гадаад улс оронд сурталчлах [www.Visitulaanbaatar.net](http://www.Visitulaanbaatar.net) цахим хуудсанд хөгжүүлэлт хийж жуулчдад хэрэгцээт цаг үеийн шинж чанартай мэдээ, мэдээллийг тогтмол /англи хэл дээр бэлтгэн/ оруулж нийт 11.300 гаруй хүнд сурталчилж, Улаанбаатар хотын өнгө төрхийг харуулах 360 градусын 4 багц 25 ширхэг зургийн санг үүсгэн байршуулж, нийслэлийн мэдээ мэдээллийн [www.Ulaanbaatar.mn](http://www.Ulaanbaatar.mn) цахим хуудастай холбож үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан ажиллаж байна.




Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Улаанбаатар хотын аялал жуулчлалын сурталчилгааг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/439 дүгээр захирамжийн хүрээнд Улаанбаатар хот болон аялал жуулчлалын гадаад сурталчилгааны мэдээ мэдээллийн цахим сэтгүүлийг /англи, монгол хэлээр/ бий болгох ажлыг “Ворлд Түдэй



Медиа Групп” ХХК-аар, Улаанбаатар брэнд лого, өнгө дизайн, уриа үг бий болгох ажлыг “Кью Эн Эс” ХХК-ийн Хөсөг төслийн багаар, Улаанбаатар хотын гудамжуудын газрын зураг, цуврал контент хийлгэх ажлыг “Сүүдэр Эй Эн Си” ХХК-аар тус тус гүйцэтгүүлж байна.



- ✓ нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр их, дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, эрдэмтэн, судлаачидтай хамтран судалгаа хийж, хэлэлцүүлэг зохион байгуулах; Улаанбаатар аялал жуулчлалын холбоо, Монгол Үндэсний Их сургуулийн судлаачидтай хамтран Монгол Улсын Аялал жуулчлалын салбарын алдагдал 2021 он судалгааны ажилд хамтран оролцсон.



Мөн “Аялал жуулчлалын салбарын бизнес эрхлэгчдэд үзүүлж буй цар тахлын нөлөө” судалгааг Монголын Үндэсний Худалаа Аж Үйлдвэрийн танхимын Аялал жуулчлалын зөвлөлийн санаачилгаар Эдийн засгийн судалгааны институтээс холбогдох байгууллагуудтай хамтран түүвэр судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. Уг судалгаагаар Аялал жуулчлалын салбар нь цар тахлын нөлөөнд хамгийн их өртөж 2021 онд ирсэн жуулчдын тоо 33.1 мянга болж 2019 онтой харьцуулахад 94.3%-иар буурсан, салбарын орлогын хувьд 2020-2021 онд 3 их наяд гаруй төгрөгийн алдагдал хүлээжээ. Судалгаанд оролцсон нийт байгууллагуудын орлого дундажаар 76.0% буурсан бол ажлын байр 63%-иар хорогдсон тооцоо судалгаа гарсан.

Тус газрын санаачлагаар Санхүү эдийн засгийн сургуультай хамтран аялал жуулчлалын салбарт нөлөөлж буй бизнесийн орчны тодорхойгүй нөхцөл байдлууд оролцогч талуудын уялдаа холбоо, хамтын стратегид хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох өнөөгийн хамтын стратегийн түвшинийг хэмжих, цаашид хөгжүүлэх боломжит хувилбарыг санал болгох зорилгоор 5 хэсэг бүхий асуумжийг боловсруулан Улаанбаатар хот болон 21 аймагт үйл ажиллагаа эрхэлж буй амралтын газар, жуулчны баазуудын захирал болон менежерүүдээс цахимаар /линк/ болон цаасаар судалгааг авч байна.

✓ **нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр гадаад, дотоодын байгууллагуудтай хамтарч ажиллах;**


Дэлхийн аялал жуулчлалын салбарын хөгжил цэцэглэлтэд хувь нэмэр оруулах, хот хоорондын хамтын ажиллагааг эрчимжүүлэх, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ болон туршлагыг түгээх зорилготой байгуулагдсан Дэлхийн Аялал жуулчлалын хотуудын холбоонд элсэх хүсэлт, байгууллагын танилцуулгыг Ази, номхон далайн бүс нутаг хариуцсан албан тушаалтанд цахим шуудангаар хүргүүлсэн.

Улаанбаатар хотын түүх, соёл, аялал жуулчлалыг дотоод, гадаадын үзэгч, сонсогчдод мэдээлэх, эх орон даяар сурталчлан таниулах, иргэдийн аялал жуулчлалын боловсролыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг сурталчлах зорилгоор 2022 онд Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз, “Улаанбаатар” телевизтэй хамтран ажиллах санамж бичиг байгуулж, хамтын ажиллагааг өргөжүүлэн ажиллаж байна.

✓ **аялал жуулчлалын салбарын хөгжлийн чиг хандлага, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах;**

Швейцарын хөгжлийн агентлаг (SDC), "Ай Хотел" ХХК-тай хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд аялал жуулчлалын салбарын нэгдсэн мэдээллийн сан, цахим экосистемийн хөгжлийг дэмжих замаар цахим сургалтын платформ бий болгох, салбар дахь бизнес эрхлэгчдийн цахим хэрэглээний чадавх мэдлэгийг дээшлүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор “My Hotel-Аялал жуулчлал, байрших үйлчилгээний салбар дахь цахим шилжилт төсөл” онлайн сургалтыг дүүргүүдийн Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулж, 120 хүнийг сургалтад хамруулав.





Бүгд Найрамдах Солонгос Улсын Соёл, аялал жуулчлалын яамны санхүүжилтээр Аялал жуулчлалын ур чадварын мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвтэй хамтран “Жуулчны баазын үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах нь” сэдэвт сургалтыг 2022 оны 06 дугаар сарын 06-10-ны өдрүүдэд зохион байгуулж 41 жуулчны баазын удирдлагыг хамрууллаа.



Зочлох үйлчилгээний салбарын үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчлах, салбарын үйлчилгээний ажилтнуудын мэдлэг, мэргэжлийн ур чадвар, ажлын үр дүнг сайжруулах, мэргэжлийн ажилтнуудтай ажлын байранд мэдлэг, туршлага солилцох боломжийг бүрдүүлэх зорилгоор зочин хүлээн авагч, өрөө үйлчилгээ, зөөгч, бартендер ажил мэргэжлээр 41 ажилтанг хамруулж батламж олгосон бөгөөд 2022 оны эхний хагас жилийн байдлаар 3 удаагийн сургалтад 201 хүн хамруулав.

✓ **жуулчдыг татах болон аялал жуулчлалын салбарт соёлын нөлөөллийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;**

❖ **Жуулчдад зориулсан эвент, арга хэмжээ зохион байгуулах ажлын хүрээнд:**

Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Нийслэлийн Соёл, урлагийн газар, Нийслэлийн Биеийн тамир, спортын газар, Улаанбаатар театр хамтран нийслэл Улаанбаатар хотод 2022 онд аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр соёл, спорт, аялал жуулчлалын арга хэмжээг зохион байгуулах асуудлыг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 06 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн Улаанбаатар хотод 2022 онд олон улсын чанартай 34 соёл, спорт, аялал жуулчлалын арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.



Улаанбаатар хотод 2022 онд зохион байгуулах аялал жуулчлалын 14 эвент арга хэмжээний видео танилцуулгыг газрын [www.ub.gov.tourism.mn](http://www.ub.gov.tourism.mn) цахим хуудас болон салбарын цахим мэдээллийн сувгаар олон нийтэд таниулан сурталчилсан.




### “Францын соёлын өдрүүд” арга хэмжээ

“Францын соёлын өдрүүд” болон “Дэлхийн театрын өдрүүд”-ийг тохиолдуулан Улаанбаатар дахь Аллианс Франсез төв, Монгол Улс дахь Францын төлөөлөгчийн газартай хамтран “Франц хэлтэн орнуудын хотхон” үзэсгэлэн, соёл, аялал жуулчлалын өдөрлөгийг 2022 оны 03 дугаар сарын 27-ны өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулж, арга хэмжээнд сургалт судалгааны байгууллага, аялал жуулчлалын компани, ресторан, төрийн бус байгууллага, франц хэлтэн орнуудын дипломат төлөөлөгчийн газар зэрэг 40 гаруй байгууллага оролцож, франц хүнсний бүтээгдэхүүн амталгаа, шөлний тэмцээн, урлаг, соёлын арга хэмжээг зохион байгуулсан. Арга хэмжээний үеэр Улсын Дуурь бүжгийн эрдмийн театрын тайзнаа тоглогдсон “Кармен” дуурийг нийслэл дэлгэцээр шууд дамжуулж олон нийтэд толилуулсан. Мөн тус газраас Жуулчны мэдээллийн төвийг ажиллуулж Улаанбаатар хотын сурталчилгааны материалыг түгээж, олон нийтэд мэдээ мэдээлэл өгч, арга хэмжээг нийт 3000 гаруй хүн үзэж сонирхсон.







### “Унгарын соёлын өдрүүд” арга хэмжээ

Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Аялал жуулчлалын арга хэмжээ зохион байгуулах тухай” А/530 дугаар захирамжийн дагуу Унгар Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамтай хамтран “Унгарын соёлын өдрүүд”-ийг Шангри-ла төв болон жанжин Д.Сүхбаатарын талбайд 2022 оны 05 дугаар сарын 13,14-ний өдөр Унгар хоолны амталгаа, хүнс, вионы амталгаа, текболын танилцуулга, урлаг соёлын арга хэмжээг зохион байгуулж, жуулчны мэдээллийн төвийг ажиллуулж, Улаанбаатар хотын сурталчилгааны 300 ширхэг материал түгээж, олон нийтэд мэдээ мэдээлэл өгч ажилласан бөгөөд арга хэмжээг 3000 гаруй хүн үзэж сонирхсон.







“Унгарын соёлын өдрүүд” арга хэмжээг угтан “Монголын Хүүхдийн ордон”, “Монголын Хүүхдийн урлан бүтээх төв”-тэй хамтран “Миний мэдэх Унгар орон” сэдэвт хүүхдийн гар зургийн уралдааныг Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд ангийн сурагчдын дунд зохион байгуулж, ирүүлсэн 209 бүтээлээс 6 шилдэг бүтээлийг шалгаруулж, байр эзэлсэн сурагчдыг “Найрамдал” олон улсын хүүхдийн цогцолборт амрах эрхийн бичиг, өргөмжлөлөөр шагнаж урамшуулав.







❖ **Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх ажлын хүрээнд:  
“Улаанбаатар травэл экспо-2022” үндэсний аялал жуулчлалын үзэсгэлэн**

Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/460 дугаар захирамжийн хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Улаанбаатар Аялал жуулчлалын холбоотой хамтран дотоодын аялагчдад дотоод, гадаадын аяллын бүтээгдэхүүн, 21 аймгийн аялал жуулчлалын хөтөлбөр маршрут мэдээ мэдээлэл, үйлчилгээг нэг цэгээс аялагч, иргэдэд хүртээмжтэй хүргэх, хариуцлагатай аялагчийг төлөвшүүлэх бүх нийтийн аяллын боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Улаанбаатар травэл экспо-2022” үндэсний аялал жуулчлалын үзэсгэлэнг “Төрсөн нутгаараа аялъя” уриан доор 2022 оны 05 дугаар сарын 27,28,29-ний өдрүүдэд 8 дахь жилдээ “Мишээл экспо” төвд зохион байгуулав.





Гадаад орнуудын аялал жуулчлалын газрууд, элчин сайдын яамдууд, соёлын төвүүд тухайн улсынхаа соёл урлаг, аялал жуулчлалыг сурталчлах, дотоод аялагчдад зориулсан аялал жуулчлалын төрөл бүрийн илтгэл хэлэлцүүлэг, богино хэмжээний сургалт, аяллын холбогдолтой нэмэлт үйлчилгээнүүд аялагчдын даатгал, түрээс, зуучлал, тээврийн үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгжүүдийн танилцуулга, аяллын клубууд аяллын бэлтгэлийг хэрхэн хангах, гэрэл зураг авах, байгальд ээлтэй аялах, зэрэг сэдвүүдээр сонирхолтой яриа танилцуулгуудыг зохион байгуулсан.

Үзэсгэлэнд Баянхонгор, Завхан, Өмнөговь, Төв, Хөвсгөл, Хэнтий, Увс, Ховд, Дундговь, Архангай буюу 10 аймгуудын байгаль орчин, аялал жуулчлалын газар, тус аймгуудад үйл ажиллагаа эрхэлдэг жуулчны бааз, рашаан сувиллын газрууд МУБИС зэрэг мэргэжлийн холбоодууд, тур оператор компаниуд, аялал жуулчлалын төсөл хөтөлбөрүүд зэрэг 106 байгууллага оролцож дотооддоо аялах аяллын маршрут, зөвлөгөө мэдээлэл, гадаад улс орон руу аялах амарч зугаалахтай холбогдсон мэдээ мэдээллийг өгч, аяллын холбогдолтой бараа бүтээгдэхүүн, үйлчилгээгээ 7000 гаруй иргэдэд мэдээлэл өгч танилцууллаа. Жим аяллын хөтөч сэтгүүлийг дотоодын аялагчдад зориулан үнэ төлбөргүй тараагдаж, WorldPlus апп үнэ төлбөргүй байршуулав.





❖ “City tour” төслийн хүрээнд:

“Сити тур” төслийг хүрээнд Улаанбаатар хот орчмын аяллын 26 маршрутыг баталж, хүүхэд, багачуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, дотоодын иргэдийн аяллын боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор “Сити тур” хотын автобустай аяллын нээлтийг Монголын Дауны холбоотой хамтран зорилтод бүлгийн хүүхэд, багачуудыг хамруулан 2022 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгууллаа.


Хотын аяллыг тусгай хөтөлбөрийн дагуу буюу астропаркын оддын театр, сансрын хөлөг, сансрын нисгэгчийн өмсгөлтэй танилцах, сансар огторгуйгаар аялах, мөн “Zoo and aquarium” амьтны паркаар зочлон шувуу, тоть, загас, сармагчин, сүүн тэжээлтэн зэрэг амьтадтай танилцах аялалд нийт 30 хүүхэд, багачууд тэдгээрийн асран хамгаалагч нарыг хамруулав.



Монгол Улсын Их сургууль, “MNB WORLD” ТВ-ийн нэвтрүүлгийн редакцтай хамтран “Сити тур” автобустай аялалд Монгол Улсын Их Сургуульд суралцдаг гадаад оюутнуудыг хамруулан 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдөр зохион байгууллаа. Аялалд нийт 7 орны Монгол хэл, соёл, түүх судлалын 30 гаруй гадаад оюутан оролцож Астропаркын оддын театр, сансрын хөлөг, сансрын нисгэгчийн өмсгөлтэй танилцаж, Цонжин болдог морьт хөшөөт цогцолборын музей болон байгууламжтай танилцлаа.



Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх” тухай А/480 дугаар захирамжийн хүрээнд “Сити тур” автобустай аяллыг “Ид шидийн орон” ТББ-тай хамтран 108 хүүхдийг, мөн Налайх, Сонгинохайрхан дүүргийн 82 хүүхэд, багачуудыг хамруулсан хотын аяллыг 06 дугаар сарын 1-ний өдөр зохион байгуулж, нийт 190 хүүхэд, багачуудыг хотын аяллын тусгай хөтөлбөрөөр аялууллаа.





14 сургуулийн 2184 сурагчдыг хамруулан 2022 оны 04 дүгээр сарын 25-аас 05 дугаар сарын 09-ний өдрийн хугацаанд хамтран зохион байгуулж, мөн “Мисс монголиа 2022” тэмцээний шилдэг 15 оролцогч 05 дугаар сарын 31-ний өдөр хотын аялалд хамрагдаж, Улаанбаатар бичиглэл бүхий хөшөө, Зайсан толгой зэрэг хотын түүх, соёлын дурсгалт газруудтай танилцсан.



“Сити тур” төсөлд 2022 оны эхний хагас жилийн байдлаар 2555 хүнийг хамруулж хотын аяллыг зохион байгуулав.

### “Нэг жуулчин-Нэг мод” жуулчин төгөл

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Нийслэлийн иргэдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, байгалийн сайханд эрүүл орчинд амрах, зугаалах нөхцөлийг бий болгох, гадаад, дотоодын аялагч, амрагчдад мод тарих боломжийг бүрдүүлэх зорилгоор “Сая жуулчин-Сая мод” аяны хүрээнд “Нэг жуулчин-Нэг мод” жуулчин төглийг Монголын Аялал жуулчлалын холбоо, аялал жуулчлалын 24 байгууллагатай хамтран Налайх дүүргийн “Шинэ Налайх” цэцэрлэгт хүрээлэнд бий болгож, мод тарих нээлтийн өдөрлөгийг 2022 оны 05 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулж, жуулчин төгөлд гацуур, шинэс, агч, нарс, хус, гүйлс, монос, нохойн хошуу, тэхийн шээг, паркийн сарнай зэрэг нийт 14 төрлийн 380 гаруй мод, бут тарьж суулгалаа.



- ✓ гадаад оронд зохион байгуулагдах аялал жуулчлалын хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн, арга хэмжээнд аялал жуулчлалын болон жуулчны үйлчилгээний байгууллагуудыг хамруулах;

#### “Монголын аялал жуулчлалын форум”

Монголын Аялал жуулчлалын холбооноос санаачлан Бүгд Найрамдах Солонгос улсын Сөүл, Бусан, Чонжү хот болон Япон улсын Токио, Шизүока, Осака хотуудад 2022 оны 05 дугаар сарын 16-20-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Монголын Аялал жуулчлалын форум” арга хэмжээнд Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Гадаад сурталчилгааны ажил зохион байгуулах тухай” А/531 дүгээр захирамжийн дагуу хамтран оролцлоо.

Тус арга хэмжээ нь Монгол улсын Аялал жуулчлалын салбарыг сурталчлах, тус улсуудад аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй шилдэг 50 байгууллага, тусгай сонирхлын аялагчдын бүлгүүдэд сурталчилгаа хийх, хэвлэл мэдээллийн байгууллага, төлөөлөлтэй уулзалт зохион байгуулах гэсэн чиглэлүүдийн хүрээнд зохион байгуулагдсан бөгөөд арга хэмжээний үеэр Улаанбаатар хотын сурталчилгааны ажлыг Бүгд Найрамдах Солонгос улсын Сөүл дахь Улаанбаатар хотын төлөөлөгчийн газар болон Монгол Улсаас Япон Улсад суугаа бүрэн эрхт Элчин сайдын яамаар дамжуулан Япон 100, Солонгос 100 ширхэг “Ulaanbaatar your gateway” сэтгүүлийг тус арга хэмжээнд хүрэлцэн ирсэн аялал жуулчлалын компаниудын бэлгийн багцад оруулж Улаанбаатар хотыг сурталчлав.



- ✓ нийслэлийн аялал жуулчлалын нөөцөд түшиглэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, шинээр бий болгох ажлыг зохион байгуулах;

Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/676 дугаар захирамжийн хүрээнд “Их тэнгэрийн амны хадны зургийн орчныг тохижуулах ажил”-ын гэрээг “Жи Эн Зэт Эф Икс” ХХК-тай байгуулж, тохижилтын ажлыг 2022 оны 04 дүгээр сараас эхлүүлж гэрээгээр хүлээсэн үүргийг хангуулж тогтмол хянан ажиллаж байна. Тохижилтын ажлын хүрээнд



явган хүний зам, авто машины зогсоол /12/, хадны зураг руу гарахад зориулсан шат, сандал, танилцуулга самбар, ногоон байгууламжийн ажлууд хийгдэж байна. Мөн тохижилтын ажлын хүрээнд Нийслэлийн Замын хөгжлийн газрын орц, гарц гаргах Ажлын хэсгийн хурлаар авто зогсоолын асуудлыг шийдвэрлүүлэхээр танилцуулгыг хийж, авто замын орц гарц гаргах зөвшөөрлүүдийг авч ажилласан.



Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх Улаанбаатар хот орчмын түүх, соёлын дурсгалыг түшиглэн хөгжүүлж, аяллын эргэлтэд оруулах ажлын хүрээнд нийслэлийн Хөрөнгө оруулалтын газраар Туулын хар Түнийн ордны туурийн зураг, төсөв боловсруулах даалгаврыг батлуулсан.

БАТГАМ  
НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ДАРГА Б.МӨНХБАТ

УЛААНБААТАР ХОТ ОРЧМЫН ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛЫГ ТҮШИГЛЭН ХӨГЖҮҮЛЭЖ, АЯЛЛЫН ЭРГЭЛТЭД ОРУУЛАХ АЖЛЫН УЛААНБААТАР ХОТЫН ЗУРАГ, ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

2022 оны 02-р сарын 25-ны өдөр № 1027/153 Улаанбаатар хот

1. Зураг төсөл боловсруулах үндэслэл	Нийслэлийн Засаг даргаар 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/219 дугаар захирамж
2. Байршил, эзэлбэр газрын хэмжээ	- Хан-Уул дүүрэг, 13 дугаар хороо, Туулын хар түнийн ордны түүх
3. Зориулалт, хүлээн зөвшөөр	- Төхөөрөлт
4. Төсвийн гүйцэтгэх хугацаа	- Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулагдсан гэрээнд заасан хугацааг үндэслэн болгоно
5. Барилгын үндсэн бүтэц, материал	- Төсөөлөр
6. Инженерийн дэд бүтэцэд тавигдах шаардлага	- Төхөөрөлтийн нөхцөл шаардлагатай бол ачаалал тооцож хангах байгууллагуудаас шинээр төхөөрөлтийн нөхцөлүүдийг гаргуулах. Тус төхөөрөлтийн нөхцөлийн хүрээнд гадна инженерийн шугам, сүлжээний зураг, төсөв боловсруулах, төхөөрөлтийн нөхцөл олгогдоггүй тохиолдолд өөрийн эрх үзэсгэлээр инженерийн шугам, сүлжээний зураг, төсөв боловсруулах холбогдох байгууллагуудтай хамтран, батлуулах. Бэлтгэл бичлэг өгөх болох.



Аяллын шинэ бүтээгдэхүүн бий болгох ажлын хүрээнд Улаанбаатар хотод ердийн хөсгийн аяллыг нэвтрүүлэх, гадаадын жуулчин, иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн аяллын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлж, нүүдлийн соёл иргэншлийг өвлөх, түгээн дэлгэрүүлэх зорилгоор хөсөг тэрэгний аяллыг зохион байгуулахаар төлөвлөж ажиллаж байна.

✓ гадаад, дотоодын жуулчдыг хэрэгцээт мэдээллээр хангах, мэдээллийн товхимлуудыг тогтмол шинэчлэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх;

Улаанбаатар хотын сурталчилгааны “Ulaanbaatar your gateway” сэтгүүлийн мэдээллийг шинэчлэн Солонгос, Япон хэл дээр 2000 ширхэг, “Сити тур” аяллын танилцуулга, газрын зураг 2500 ширхэг нийт 4500 ширхэг сурталчилгааны материал хэвлүүлж, гадаад, дотоодын үзэсгэлэн, арга хэмжээнд иргэд хүргэж Улаанбаатар хотыг сурталчлан ажиллаж байна.




Нийслэлийн хэмжээнд соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах арга хэмжээний хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Аян зохион байгуулах” А/648 дугаар захирамжийг батлуулж, “Бүх нийтийн аяллын боловсролыг нэмэгдүүлэх” аянг “Нона фамили” ХХК-тай хамтран хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.

“Хотын соёлыг төлөвшүүлж, түгээн дэлгэрүүлэх” цахим аяны хүрээнд байгаль дэлхийгээ хайрлан, эко амьдралын хэв маягийг хэвшүүлэхийг уриалан байгаль орчноо хайрлах 50 энгийн арга, соёлтой, ул мөргүй аялцгаая зурагт мэдээлэл 3, видео танилцуулга 3 бэлтгэн газрын цахим хуудаст байршуулан 8288 хүнд сурталчилсан.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын пэйж хуудсанд 75 удаагийн цаг үеийн холбоотой болон арга хэмжээний, 5 удаагийн захирамж шийдвэртэй холбоотой мэдээ нийт 80 удаагийн цаг үеийн холбогдолтой мэдээлэл оруулж 78 029 гаруй иргэд олон нийтэд хүргэсэн байна.








✓ **нийслэлийн хэмжээнд аялал жуулчлалын салбарын мэдээллийн санг хөтлөх;**

Улаанбаатар хотод идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллага, олон улсын чанартай зохион байгуулагддаг аялал жуулчлалын томоохон үзэсгэлэн, арга хэмжээ болон хот орчмын болон аймаг орон нутгийн очиж үзэж болох дурсгалт газрууд, аяллын маршрут, тусгай сонирхлын аялал зохион байгуулдаг сайн дурын клубууд судалгааг шинэчлэн гарган мэдээллийн сан үүсгэсэн. Мөн Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвд 10 төрлийн 1500 гаруй байгууллагын мэдээллийн санг тогтмол шинэчлэн гадаад, дотоодын иргэд, жуулчдыг хэрэгцээт мэдээллээр ханган ажиллаж байна.

Байгууллагын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоотой үзүүлэлт, тоон мэдээлэл болон үзвэр, үйлчилгээний газар, сүм, хийд /шашны ангиллаар/, бэлэг дурсгалын дэлгүүр, гар урлалын төвүүдийн тоо, түүх соёлын үл хөдлөх дурсгал, ресторан, баар, цэнгээний газрын тоон мэдээлэл үүсгэж, танилцуулгын хамт нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн.

✓ **“жуулчны мэдээллийн төв”-үүдийн үйл ажиллагааг өргөжүүлэх;**

Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Улаанбаатар хотын жуулчны мэдээллийн төв ажиллуулах тухай” А/210 дугаар захирамжийн хүрээнд гадаад, дотоодын иргэд, жуулчдад хэрэгцээт мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгөх зорилгоор Нийслэлийн Засаг захиргааны IV байр, Хонхор тосгон, Хөшигийн хөндийн “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудлын “Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төв”-ийг тогтмол ажиллуулж, Үндэсний онцлог бүхий жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвийг шинээр Ж.Сүхбаатарын талбайд зөөврийн зориулалтаар, “Төв шуудан”, “Улаанбаатар төмөр замын буудал”-д ажиллуулахаар судалгаа хийж, зураг төслийг боловсруулж, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.



✓ **жуулчдын санал, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх;**

Гадаад, дотоодын жуулчдын санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, мэдээлэл, зөвлөгөөг түргэн шуурхай, цаг алдалгүй хүргэх зорилгоор Жуулчны лавлах утас 70108687

дугаар ажиллуулж 2022 оны эхний хагас жилийн байдлаар нийт 4300 гадаад, дотоодын иргэд, жуулчдад мэдээлэл өгч ажиллалаа.

-Тайлант хугацаанд аялал жуулчлалын 2 арга хэмжээ, 2 үзэсгэлэнд “Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвийг ажиллуулж 3500 гаруй гадаад, дотоодын иргэд, жуулчдад мэдээлэл өгсөн.

- ✓ гадаад, дотоодын жуулчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй орчинд зорчих, аялах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах.

Гадаад, дотоодын иргэд, жуулчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй аялах видео контент, аяллын үед коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж бүхий 2 төрлийн контентыг зочлох үйлчилгээний 10 байгууллагын утгах үйлчилгээ, хүлээлгийн танхимд байршуулж, мөн агаарын хөлгийн бүхээг болон цахим сувгуудаар түгээх ажлыг зохион байгуулж байна.



- ✓ **Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийн хүрээнд:**

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч газрын даргатай байгуулсан 2022 оны “Хариуцлагын гэрээ”-г 6 бүлэг 33 заалтаар боловсруулан баталгаажуулж, “Хариуцлагын гэрээ”-ээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-д тусгагдсан зорилт, арга хэмжээ, Нийслэлийн Хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд газрын чиг үүрэгт хамаарах хэрэгжилтийг хангах, төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэн хариуг шуурхай өгч, хүнд суртал, чирэгдэлгүй ажиллах, гэрээний хэрэгжилтийг тайлагнах зэрэг 17 заалт бүхий үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж хэрэгжилтийг ханган ажилласан.

Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох дүрэм, журамд нийцүүлэн боловсруулж 3 зорилтын 58 арга хэмжээг хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаар баталгаажуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулж, 2022 оны эхний хагас жилийн байдлаар 80.8 хувийн хэрэгжилттэй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоолоор батлагдсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам”-аар нийслэлийн Засаг даргын агентлагын дарга тамга хэрэглэх болсонтой холбогдуулан хүсэлтийг

хүргүүлж, дүрэм, журамд нийцүүлэн тамга, тэмдэг шинээр хийлгэх ажлыг гүйцэтгүүлж, үйл ажиллагаандаа мөрдөн ажилласан.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/599 дүгээр захирамжаар нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх “Найрсаг Улаанбаатар-2” арга хэмжээг батлуулж, 7 зорилтын 77 үйл ажиллагааг 2022-2025 оны хооронд хэрэгжүүлэх төлөвлөгөөг хамтран хэрэгжүүлэх холбогдох байгууллагуудад хүргүүлж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

“Ковидын дараах Нийслэлийн аялал жуулчлалыг сэргээж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний төслийг боловсруулж, Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Аялал жуулчлалын Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд “Шинэ сэргэлтийн бодлого”-той уялдуулан батлуулахаар хүлээгдэж байна.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2022 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 01 дүгээр удирдамжийн хүрээнд Нийслэлийн Дотоод аудитын албанаас тус газрын 2020, 2021 оны үйл ажиллагаанд хийсэн аудит, хяналт шалгалтын дүгнэлт, зөвлөмжийг газрын нийт албан хаагчдад танилцуулан, үйл ажиллагаанд хэрэгжүүлж зөвлөмжийн тайланг хугацаанд нь нийслэлийн Дотоод аудитын албанд хүргүүлэв.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2021 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх 5 зорилтын 31 заалт арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

#### **б./ Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах чиглэлээр:**

##### **✓ “Төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:**

“Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан “Хууль эрх зүй”, “Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга”, “Алсын хараа-2050”, “RISE-Academy”, “Төслийн удирдлагын үндэс”, Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт зэрэг 8 удаагийн сургалтад 11 удирдах болон захиргааны албан хаагч хамдагдаж мэдлэг чадвараа дээшлүүлсэн.

Байгууллагын албан хаагчдын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2022 оны сургалтын төлөвлөгөөний хүрээнд “YES МОНГОЛ БИЧИГ” аяны хүрээнд “Монгол бичгийн сургалт”-ыг 3 сарын хугацаанд, “Хүүхэд хүмүүжүүлэх арга ба сэтгэл зүй”, “Дипломат ёслол”, “Хамтын оролцоотой аялал жуулчлал”, “Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах нь” сэдэвт 5 удаагийн сургалтад давхардсан тоогоор 84 албан хаагч, гадаад олон улсын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран “Төрийн байгууллагын ёс зүйн зөвлөлийг чадавхжуулах нь”, “Архив албан хэрэг хөтлөлт”, “Ахисан түвшний Жендерийн дүн шинжилгээ”, “Eco-cultural Tourism for Local Activation” 5 удаагийн сургалтад 15 албан хаагч буюу 2022 оны эхний хагас жилийн байдлаар 18 удаагийн сургалтад давхардсан тоогоор 113 албан хаагч хамрагдсан.



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ (2022 он)

№	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар	
Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх							
1.	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	1.1.	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо:	10	18	1.Нэг удаагийн сургалтын хугацаа 4 цагаас дээш бол тайлагнана. 2.Зорилтот түвшин хэсэгт байгууллагын сургалтын төлөвлөгөөнд туссан дүнг бичнэ. 3.Гадаад улс орон, хилийн чандад хамрагдсан сургалтыг тайлагнана. 4. Дэлгэрэнгүй судалгаа мэдээллийг тайланд хавсаргасан байна.	
		Үүнээс	Ажлын байран дахь сургалт	3	7		
			Мэргэшүүлэх сургалт	1	2		
			Туршлага солилцох арга хэмжээ	1	1		
		1.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	18	19		
			Үүнээс	Эмэгтэй албан хаагч	13		13
				Эрэгтэй албан хаагч	5		6
				Удирдах албан тушаалтан	4		3
		1.3.	Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	14	16		
			Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	90-ээс дээш	100%		
2.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад	2.1.	Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо	1	1		
		2.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	1	10		
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	1	8		
			Эрэгтэй албан хаагч	0	2		



✓ “Хүний нөөцийн хөгжил, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/1059 дүгээр захирамжийн хүрээнд газрын даргын 2022 оны А/03 дугаар тушаалаар албан тушаалын жагсаалтыг шинэчлэн баталж, Төрийн албаны зөвлөлийн [www.hr.csc.gov.mn](http://www.hr.csc.gov.mn) цахим системд байгууллагын бүтэц зохион байгуулалт, албан тушаал, албан хаагчдын мэдээллийг шинэчлэн бүрэн оруулсан.

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-д хүрээнд тус газрын 14 албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж хянуулан танилцуулж, Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн “Зөвшөөрөл олгох тухай” 323 дугаар тогтоолын хүрээнд газрын даргын 2022 оны А/24 дүгээр тушаалаар төрийн захиргааны /ТЗ/ 14, төрийн үйлчилгээний /ТҮ/ 3 нийт 17 албан тушаалын тодорхойлолтыг батлав.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох тухай” А/641 дүгээр захирамжийн дагуу 4 албан хаагчид төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг олгуулсан.

Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан албан хаагчдын гэр бүлийн гишүүдийг хамруулан “Гэр бүлийн өдөрлөг”-ийг 2022 оны 05 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулж хүндэтгэл үзүүлэв.



**в/. иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн чиглэлээр:**

Тус газарт 2022 оны эхний хагас жилийн байдлаар нийт 8 өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авч 100% шийдвэрлэсэн. Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байхгүй. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явцад Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга, өргөдөл, гомдол хариуцсан албан хаагч тогтмол хяналт тавьж, тайлан мэдээг сар бүр гарган Газрын даргад танилцуулан ажилласан. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 11 хоног 4 цаг 32 минут байна.

**г./ Бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны чиглэлээр:**

✓ **Улаанбаатар хот орчмын түүх, соёлын дурсгалыг түшиглэн хөгжүүлж, аяллын эргэлтэд оруулах төсөл, арга хэмжээ**

Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Эрх шилжүүлэх тухай” А/219 дүгээр захирамжаар нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх Улаанбаатар хот орчмын түүх, соёлын дурсгалыг түшиглэн хөгжүүлж, аяллын эргэлтэд оруулах төсөл, арга хэмжээний эрхийг нийслэлийн Аялал жуулчлалын газарт шилжүүлж, НХААГ/202212090 тендер шалгаруулалтын дугаартай 1,000.0 төсөвт өртөгтэй 3 багц төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 1 багц ажил буюу “Бэлхийн амны Хүннүгийн язгууртны булш” цогцолборын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах, эрх олгох зөвлөмжийг хүргүүлсэн бөгөөд шалгарсан “Өндөрхаан-Өргөө” ХХК-тай холбогдох газар гэрээ байгуулж, тохижилтын ажлын зураг, төсвийг Барилгын хөгжлийн төвд хүргүүлж, экспертийн томилгоог хийлгэж, магадлалаар оруулсан.

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн холбогдох заалтын хүрээнд НХААГ/202212090-2 багц буюу “Гачууртын амны хадны зураг” , НХААГ/202212090-3 багц буюу “Ар гүнт дэх дөрвөлжин булш” түүх, соёлын дурсгалын орчныг тохижуулах ажлын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зогссон бөгөөд явцын мэдээллийг <https://report.ub-procurement.mn/> цахим хаягт тухай бүр оруулан ажиллаж байна.

**д/. нийслэлийн хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд оруулсан тайлан мэдээ**

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, 2021 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 374 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ,

үнэлгээ хийх нийтлэг журам"-ын хүрээнд бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт 2022 оны эхний хагас жилийн байдлаар Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлт 76.6%, "Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 1 зорилтын 3 арга хэмжээний биелэлт 63.3%, "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 5 зорилтын 11 арга хэмжээний биелэлт 57.0%, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн байгаль орчин, аялал жуулчлалын салбарт 2022 онд хамтран ажиллах гэрээнд туссан арга хэмжээний 1 зорилтын 15 арга хэмжээний биелэлт 60.9%, "Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөө"-ний 1 зорилтын 19 арга хэмжээний биелэлт 62.0%-ийн хэрэгжилттэй байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт 2022 оны эхний хагас жилийн байдлаар 90.0%, захирамжлалын баримт бичгийн 86.2% хэрэгжилттэй үнэлэгдэж, тайлан мэдээг хугацаанд нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн бөгөөд [www.monitoring.ulaanbaatar.mn](http://www.monitoring.ulaanbaatar.mn) цахим програмаар тайлагнасан.

Нийслэлийн удирдах ажилтнуудын 8 удаагийн шуурхай зөвлөгөөнөөс нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаас өгсөн үүрэг, даалгавраас чиг үүргийн хүрээнд заалт тус бүрээр биелэлтийг ханган, хэрэгжилтийг тухай бүр хугацаанд нь [www.ulaanbaatar.mn](http://www.ulaanbaatar.mn) програмаар тайлагнан ажиллав.

## **ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ**

### **✓ Үйл ажиллагааны ил тод байдал**

Байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, дүрэм, бүтэц, чиг үүргийг байгууллагын цахим хуудсанд байршуулж, тэдгээрийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан, үр дүнг <https://tourism.ub.gov.mn/> сайтад тухай бүр шинэчилэн байршуулав

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган байгууллагын жилийн төсөв, төсвийн гүйцэтгэл, төсвийн хэмнэлт хэтрэлт, аудитын зөвлөмжийн тайлан, санхүүгийн тайланг тогтоосон хугацаанд тайлагнаж, ндсэн үйл ажиллагааны чиглэлээр 17, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны чиглэлээр 12, бусад чиглээр 15 буюу 44 ажлын мэдээллийг [www.info.shilendans.gov.mn](http://www.info.shilendans.gov.mn) цахим санд оруулж ил тод байдлыг ханган ажилласан.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын пэйж хуудсанд 75 удаагийн цаг үеийн холбоотой болон арга хэмжээний, 5 удаагийн захирамж шийдвэртэй холбоотой мэдээ нийт 80 удаагийн цаг үеийн холбогдолтой мэдээлэл оруулж 78 029 гаруй иргэд олон нийтэд хүргэсэн байна.

### **✓ Хүний нөөцийн ил тод байдал**

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм", байгууллагын "Ёс зүйн зөвлөл"-ийг баталсан газрын даргын тушаалыг <https://tourism.ub.gov.mn/> цахим хуудаст байршуулсан.

Албан хаагчдын нэр, албан тушаал, харилцах утас, цахим хаяг, байгууллагын мөрдөгдөж байгаа дүрэм, журмыг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт тухай бүр шинэчлэн байршуулав.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг тайлагнадаг 5 албан тушаалтан хугацаанд мэдүүлсэн.

## ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД МЭДЭЭЛЭЛ

### **а./ Чиг үүргийн хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны бусад байгууллагатай ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр:**

Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Эрх шилжүүлэх тухай” А/219 дүгээр захирамжаар нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх Улаанбаатар хот орчмын түүх, соёлын дурсгалыг түшиглэн хөгжүүлж, аяллын эргэлтэд оруулах төсөл, арга хэмжээний зураг, төсөв боловсруулах даалгаврыг нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар, тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар, тохижилтын ажлын зургийг нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газраар тус тус батлуулсан.

Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/292 дугаар захирамжийн хүрээнд Хотын соёлыг төлөвшүүлэх, иргэдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчин, нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор цагийн хязгаартай ажиллах авто машингүй гудамж, талбайн судалгааг гаргах, төсөл хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд Соёлын яам, нийслэлийн “Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв” НӨҮГ, “Улаанбаатар хөрөнгө оруулалт менежмент ҮЦК” ХХК-ийн удирдлага холбогдох албан тушаалтнуудтай уулзалт хийж автомашингүй гудамжны төслийн талаар хамтран ажилласан.

Улаанбаатар хотод соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, чөлөөт уран бүтээлчдийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, аялал жуулчлалын цогцолбор бий болгох зорилгоор Сүхбаатар дүүрэгт байрлах Үндэсний соёл амралтын хүрээлэнд “Метро стрийт” гэрэлт гудамжны тохижилтын ажлын зураг төсөлд тусгах саналыг нийслэлийн Хот тохижилтын газарт хүргүүлсэн.

Улаанбаатар хотод эко аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, ажлын байрыг нэмэгдүүлэх, аялал жуулчлалын цогцолбор бий болгох зорилгоор Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороонд байрлах “Шувуут нуур”-ыг аялал жуулчлалын мега гудамж болгохыг дэмжиж байгаа бөгөөд тохижилтын ажлын зураг төсөлд тусгах саналыг Олон улсын худалдаа логистикийн төв ХК-д албан бичгээр хүргүүлсэн.

Нийслэлийн жижиг дунд үйлдвэр, үйлчилгээний салбарт инновац хөгжүүлэх боломж, шийдэл-2022 форумд оролцсон. Форумын хүрээнд оролцогч IT-ийн компаниудтай цахим аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийг хэрэгжүүлэх тал дээр хамтран ажиллахаар болсон.





Нийслэлийн Дагуул хот, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн газраас зохион байгуулсан дагуул хот, эдийн засгийн тусгай бүс байгуулах газрын байршилтай танилцах аяллын хүрээнд Нийслэлийн Аялал жуулчлалын газрын удирдлага, холбогдох мэргэжилтэн Улаанбаатар хот орчмын эдийн засгийн болон бүс нутгийг хөгжүүлэх боломжтой таван байршилтай танилцсан. Цаашид дагуул хот, эдийн засгийн тусгай бүс байгуулах ажил дээр нэгдсэн нэг концепц барьж хамтран ажиллахаар шийдвэрлэсэн.



Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас санаачлан зохион байгуулсан “Аялал жуулчлалын тухай хууль, тогтоомжийг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагыг тодорхойлох цуврал хэлэлцүүлэг”-т оролцож, тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх арга зам, хууль тогтоомжийг сайжруулах чиглэлээр саналаа хүргүүлсэн бөгөөд тус хэлэлцүүлэгт нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэс, нийслэлийн Татварын газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны мэргэжилтнүүдийг хамруулсан.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

МОНГОЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХОЛБОО

#FEEL MONGOLIA

МОНГОЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХОЛБОО

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭР, ДҮРЭМ ЖУРАМ, СТАНДАРТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ХЭРГЭГЦЭЭ ШААРДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ ЦУВРАЛ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Цаг уур, орчны шинжлэгдэлийн газрын хурлын заал

№	Өргөсний	Хурал үргэлжлэх	Хугацаа
1	Тур оператор, тур агентын үйл ажиллагаа эрхлэх Аялал жуулчлалын байгууллага хэрэгсэлийн үйл ажиллагаа эрхлэгчид жуулчны бааз, ажилтны газар, тэр буудал, дэн буудал	Арсан санал, дүгнэлтийн дагуу хууль тогтоомжийн төслийн санал боловсруулах.	2022.03.04-ний өдөр 09.00-13.00 цагт
2	Зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх	Арсан санал, дүгнэлтийн дагуу хууль тогтоомжийн төслийн санал боловсруулах.	2022.03.07-ний өдөр 09.00-13.00 цагт
3	Аялал жуулчлалын боловсрол, судалгаа шинжилгээний байгууллагууд, нэгж тайлбарлагч	Арсан санал, дүгнэлтийн дагуу хууль тогтоомжийн төслийн санал боловсруулах.	2022.03.10-ний өдөр 09.00-13.00 цагт
4	Аялал жуулчлалын чөлөөтэй хөргөгч буй төсөл, төлөвлөгөө	Арсан санал, дүгнэлтийн дагуу хууль тогтоомжийн төслийн санал боловсруулах.	2022.03.15-ний өдөр 09.00-13.00 цагт
5	Төрийн захиргааны байгууллага болон харьяа байгууллага, холбооноос мэргэжлийн байгууллага	Арсан санал, дүгнэлтийн дагуу хууль тогтоомжийн төслийн санал боловсруулах.	2022.03.17-ний өдөр 09.00-13.00 цагт
6	Холбоо үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх	Арсан санал, дүгнэлтийн дагуу хууль тогтоомжийн төслийн санал боловсруулах.	2022.03.22-ний өдөр 09.00-13.00 цагт
		Арсан санал, дүгнэлтийн дагуу хууль тогтоомжийн төслийн санал боловсруулах.	2022.03.25-ний өдөр 09.00-13.00 цагт

ОРОЛЦОГЧИД: АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖИЛТНИЙ ТӨС ХААГААРТ: 1008 /САЛТНТНТ: 1008 /17777061 / МОНГОЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХОЛБООНЫ 10087829 УТСАНД ХОЛБОГДОЖ БҮРТГҮҮЛЭХ ҮГ.

САНАМЖ: АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖИЛТНИЙ ТӨС ХААГААРТ: 1008 /САЛТНТНТ: 1008 /17777061 / МОНГОЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХОЛБООНЫ 10087829 УТСАНД ХОЛБОГДОЖ БҮРТГҮҮЛЭХ ҮГ.



Монголын Аялал жуулчлалын холбоотой хамтран “TOURISM TIME-2” уулзалт, арга хэмжээг 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулж, арга хэмжээнд Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Сандагсүрэн, болон аялал жуулчлалын бизнес эрхлэгч компанийн төлөөлөл оролцож тус газраас “Нийслэлд болох эвент арга хэмжээний

танилцуулга” мэдээлэл хийсэн бөгөөд Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга Д.Батсүх болон Монголын Аялал жуулчлалын холбооны Ерөнхийлөгч Д.Гантөмөр нар хамтран ажиллах ажлын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газраас “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд “Аялал жуулчлалын үйлдвэрлэлийг хөгжүүлж, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, аялал жуулчлалын бүс нутгийн хөгжлийг хангах, орон нутгийн түүх, соёл, угсаатны өвд тулгуурласан соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх” дэвшүүлсэн зорилтын хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 04 дүгээр сарын 04-ний өдөр зохион байгуулагдсан 21 аймгийн аялал жуулчлалын асуудал хариуцсан байгууллагын удирдлагууд, мэргэжилтнүүд, мэргэжлийн холбоодод зориулсан “Аялал жуулчлалын холбоодын үндэсний чуулган”, “Орон нутгийн аялал жуулчлалын хөгжлийн асуудал” сургалт, уулзалтад оролцож Улаанбаатар хотод зохион байгуулагдах эвент арга хэмжээний талаар танилцуулсан.



Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Монголын Аялал жуулчлалын холбоо санаачлан “Зочлох үйлчилгээний салбарын сургалт хөгжлийн төв”, “Монголын гастрон ом аялал жуулчлалын холбоо” ТББ-тай хамтран аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулдаг жуулчны үйлчилгээний байгууллагууд, тур операторуудын туршлага солилцох “Аялал жуулчлал – Бизнес хэлцэл”-2022 арга хэмжээг 4 дүгээр сарын 13, 14-ний өдрүүдэд “Баянгол зочид” буудалд зохион байгууллаа. Арга хэмжээнд жуулчны үйлчилгээний 80 гаруй байгууллага, 200 орчим тур оператор компанийн төлөөллүүд оролцож, жуулчны үйлчилгээний байгууллага, тур операторуудад нэг дор гэрээ хийж хамтран ажиллах боломжийг бүрдүүлсэн.



“Улаанбаатар марафонд нэгдэцгээе” Нийслэлийн Засаг даргын нэрэмжит цомыг 4 дүгээр сарын 18-ны өдөр хүлээн авч, аяны хүрээнд хамт олныхоо дунд ажлын байрны дасгал хөдөлгөөн, Сагсан бөмбөг зэрэг спортын тэмцээн, уралдаан зохион байгуулж, Монголын Аялал жуулчлалын холбооны 30 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан

"TOURISM CUP" 2022 сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн, "Улаанбаатар марафон"-д албан хаагчид оролцсон.

**б./ Хөрөнгө, санхүүжилтийн асуудлаас бусад үндсэн үйл ажиллагаа явуулахад гарч байгаа хүндрэл, бэрхшээл болон цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаарх санал, хүсэлт:**

- ✓ Аялал жуулчлалын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг батлуулах, түүнийг дагасан холбогдох дүрэм, журмыг шинэчлэх
- ✓ Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор Нийслэл хотын албан татварын орлогоос тодорхой хувийг аялал жуулчлалын салбарт эргүүлэн зарцуулах талаар дүрэм, журамд тусгах
- ✓ Нийслэл хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх сангийн журмыг боловсруулан батлуулах